

**“ХУУРЫН ҮЛГЭРИЙН СУДЛАЛ” БҮТЭЭЛИЙН ТУХАЙ
ХУУЧ ЯРИА ӨРНҮҮЛЭХҮЙ
(Шүүмж)**

Г. Галбаяр*

“Хуурын үлгэрт баялаг сайхан үг хэлээр орчин тойрныг илэрхийлж, урам байдлыг үзүүлж, хүмүүсийн үг яриаг илтгэн, дүр төрхийг зураглаж, хөдлөл байдлыг дүрслэн, хүмүүсийн дотоод сэтгэлгээг дэлгээж, хуурчийн үзэл сэтгэлгээг шууд илтгэдэг” (114 дүгээр тал), “Хуурын үлгэрийн үйл явдал нь хүмүүсийн дүрийн зан чанарт суурилж, түүнд тохирч, түүнийг илрүүлсэн байх ёстой, зан чанараас салбал үйл явдлын хөгжилт гэж байж чадахгүй” (138-139 дүгээр тал) гэх зэрэг дүгнэлтүүдийг нэг сэдвийн гүн рүү ярган орж, авьяас мэдрэмжийг төгс хослуулан судалгаа шинжилгээний олон арга барилын уулзвар зангилаанд дулдуйдаж шинжлэх ухааны онолын нарийн үзэл баримтлал дээр тулгуурлан хийсэн бүтээл бол БНХАУ-ын Бээжингийн Төвийн Үндэстний Их Сургуулийн профессор Б. Цогт багшийн “Хуурын үлгэрийн судлал” юм. Энэ нэг сэдэвт бүтээлийг өнгөрсөн жил Монгол Улсын Их Сургуулийн Улаанбаатар Сургуулийн Монгол Судлалын Төвөөс эрхлэн кирил бичгээр Улаанбаатар хотноо хэвлүүлсэн байна. Эрдэмтэн Б. Цогтыг бүтээлийнх нь хойт талын хавтасны ард “1964 оны хавар Өвөр монголын Хорчин зүүн гарын хойд хошууны Хайсгай сумын Буян багшийн ахмад хөвгүүн нь болж төржээ. 1988 онд Бээжингийн Төвийн Үндэстний Их Сургуулийн монгол хэл утга зохиолын салбараас төгсөж мөн жилдээ салбарынхаа монгол аман зохиолын чиглэлээр аспирантад шалган орж, гурван жил суралцав. 1991 онд Ляонингийн сурган хүмүүжлийн дээд сургуульд хуваагдан долоон жил багшилжээ. 1998 онд Мандах (Бээжингийн Төвийн Үндэстний Их Сургууль) профессорын докторантаар шалган орж, Дундад улсын умардын цөөн тоот үндэстний аман зохиолын чиглэлээр гурван жил суралцаж доктор цол хамгаалаад сургуульдаа үлдэж эрдэм шинжилгээний ажлыг хийж буй” хэмээн танилцуулжээ. Энэ танилцуулга дээр нэмэн өгүүлэхэд Профессор Б. Цогт энэ бүтээлээс гадна мэргэжил нэгт эрдэмтэдтэй хамтран болон дангаараа бие даан “Лувсанчойданы судлал” тэргүүтэй хэд хэдэн ганц сэдэвт бүтээл, олон арван өгүүллийг бичиж монгол, хятад, япон, герман зэрэг хэлээр хэвлүүлсэн байна. Мөн сүүлийн жилүүдэд Монгол, Япон, Герман зэрэг олон оронд очиж тэндэхийн судлаач эрдэмтэдтэй хамтран судалгаа шинжилгээ хийж буй нэртэй эрдэмтэн юм.

Б. Цогтын “Хуурын үлгэрийн судлал” бүтээл удиртгал бүлэг, үндсэн 5 бүлэг, гол ашигласан ном өгүүллүүд гэсэн хэсгүүдээс бүрдэж байна. Дүгнэлтүүдийг зохиолын

* МУИС-ийн МХСС-ийн Утга зохиолын тэнхим

бүлэг хэсэг бүрийн ард дор дор нь хийсэн нь судлаачийн туршлага, судлагаа шинжилгээний арга барилын онцлогийг харуулна.

Удиртгал бүлэгтээ судлаач уг судалгааг хийх болсон үндэслэлээ нэгд, хуурын үлгэр хамгийн их дэлгэрч тархсан Хорчин нутгийн хүний хувьд хар багаасаа хуурын үлгэрийг ихэд сонирхож эхэлсэн, хоёрт, нэгэн үеийн монголчуудын оюун сэтгэлгээний илэрхийлэл болсон хуурын үлгэр сүүлийн жилүүдэд устах аюулд ороод байгаа тул хуурын үлгэрийн өв уламжлалыг бүрэн дүүрэн цуглуулан цогцоор нь судлан шинжилж, цаашид дахин ямар арга замаар дэлгэрүүлж, хойч үеийнхэнд уламжлуулахыг, гуравт, хуурын үлгэрийг дотоод, гадаадад хэсэг тасгаар судлан шинжилж ирсэнийг нэгтгэн иж бүрнээр нь тогтолцоотой судлах шаардлагаас эхлэлтэйг өгүүлж, судалгаа шинжилгээгээ хэрхэн хийсэн арга барил, онолын үзэл баримтлал зэргийг өгүүлсэн аж. Энэ нь тухайн судалгааны ажил зайлшгүй хийвэл зохих сэдэв байсныг илэрхийлэхийн зэрэгцээ шинжлэх ухааны үндэслэлтэй нэгээс нөгөө нь ургаж, эргээд үндсэн зорилгодоо зангилагдсан нарийн судалгаа болсныг харуулж байна.

“Хуурын үлгэр ба түүний үүсэл хөгжил” гэсэн тэргүүн бүлэгтээ “Хуурын үлгэр гэдэг бол хуурчаас монгол үндэстэн ба бусад ах дүү үндэстний эрт эдүгээгийн ямар нэгэн амьдралаас сэдэв авч, бүхэл бүтэн үйл явдалтай, баатрын дүр бүхий үлгэрийг доор хөгийн дөрвөн утасст хуураар хавсарган, үргэлжилсэн үг ба холбон шүлэглэх хэлбэрийг ээлжлэн хэрэглэж хэлдэг нэг зүйлийн хэлж дуулах урлаг болно” (49 дүгээр тал) хэмээн тодорхойлсон байна. Энэ нь хуурын үлгэр мангасын үлгэр¹ хийгээд явган үлгэрээс эрс ялгаатай бие даасан зүйл болохыг батлана. Түүгээр ч барахгүй манай судлаачдын дунд дэлгэрсэн “Бэнсэн үлгэр бол хуурын үлгэр, хуурын үлгэр бол бэнсэн үлгэр” гэсэн ойлголтыг няцааж тус тусдаа бие даасан зүйл болохыг баталж, тус тусынх нь онцлог, хоорондын холбоо хамаарлыг гаргаж тавьжээ. Улмаар хуурын үлгэрийн үүсэл хөгжлийг өмнөх үеийн судлаачдын судалгаа шинжилгээний үр дүн хийгээд монголчуудын эрхэлж ирсэн аж ахуй, соёл сэтгэлгээний хөгжилтэй холбон судлаад “Хуурын үлгэр бол зүүн орны монголчуудын аж ахуйн хэлбэрийн хувирал, хятад үндэстний соёлын нөлөөлөл ба монгол аман зохиолын уламжлалтай нягт холбоотой байж, 17-р зууны сүүл 18-р зууны эхээр зүүн орны монголчуудын мангасын үлгэрийн суурин дээр Зостын чуулганы Түмэд зүүн хошуунаас үүсэн буй болсон юм. Ингээд аажмаар тогтворжиж, умарш уламжлагдан дэлгэрээд бүхий л зүүн орны монголчуудын дунд үндсэндээ тархсанаар үл баран Монгол улсын Дорнод аймаг, Төв аймаг хүртэл уламжлагдаж тун их хөгжилтэй байсан” (5 дугаар тал) хэмээн хуурын үлгэрийн үүсэл хөгжил, тархацыг тодруулсан байна. Үргэлжлүүлэн хуурын үлгэрийн онцлог болох зан үйл, хөгжим, аялгуу, дүр дүрслэл зэргийг явган үлгэр, тууль (мангасын үлгэр), бэнсний үлгэртэй харьцуулан судлажээ. Тус бүлгийн төгсгөлд хуурын үлгэрийг орчин үед хэрхэн дэлгэрүүлж, хойч үедээ уламжлуулах аргыг өөрийн судалгаандаа үндэслэн агуулгын талаас “1. Монгол үндэстний эрт эдүгээгийн амьдралаар сэдэвлэсэн үлгэрийг илүү хэлж одоох амьдралаар голдуулна, 2. Хятад үндэстэн хийгээд дэлхийн бусад улс гүрний шилдэг зохиолыг хуурын үлгэр болгон хэлэхдээ одоо үеийнхийг илүү чухалчилна, ... Хэлбэрийн талаас 1. Охор авсаарыг

¹⁾ Зүүн орны Монголчууд туулийг цуурын үлгэр буюу мангасын үлгэр гэж хэлдэг. Учир нь өнгөрсөнд тууль хайлахад туульч нар бүр цуураар хавсарган хөгжимдөж байсан юм. Туулийн сөрөг талын баатар нь бүр мангас болохоор энэ дэх монголчууд туулиа бас мангасын үлгэр гэж, туулчиа мангасч (мангас) хэмээн нэрлэж байна. (49 дүгээр тал)

эрхэмлэн урт сунжрууг цээрлэнэ, 2. Хуурын үлгэрийн тайзны урлагийн шинжийг чангатгаж, телевизээр илүү нэвтрүүлнэ, ... Бусад талаар, 1. Дараа нэг үеийн хуурчийн хүмүүжүүлэхэд удирдлагаас хүндэтгэн эд бодис ба хүний хүчийг гүйцэд хангана, 2. Одоогийн амьд сэрүүн байгаа алдарт хуурч нарын идэвхжилийг гүйцэд бадруулж хуурын үлгэрийн гарах замыг судлан шинжилнэ, ..." (105-106 дугаар тал) гэх мэтээр 11 зүйлийн гаргалгааг гаргаж тавьжээ. Ийнхүү хуурын үлгэрийн онцлог мөн чанарыг тодруулан түүхэн хөгжил хувьслыг судлаад цаашид хуурын үлгэрийг хөгжүүлэн дэлгэрүүлэх талаар зохих гаргалгаа гаргаж тавьсан нь нэн ач холбогдолтой юм.

Урлаг, уран зохиол хүний сэтгэлийг татдаг дотоод увдистай. Хуурын үлгэрийн энэ увдисыг "Хуурын үлгэрийн урлаг" гэсэн дэд бүлэгтээ судлан шинжилж тодруулсан байна. Хуурын үлгэрийн уран сайхны онцлогийг тодруулахдаа хуурын үлгэрийн хэл, дүр дүрслэл, зохиомж үйл явдал, эгшиг аялгуу гэсэн хэсгүүдэд олон талын харьцаа холбоонд нь нарийвчлан задлан шинжилжээ. Тухайлбал, хуурын үлгэрийн сонсгол талын гол зүйл болох ая эгшгийг арвин баялаг жишээ баримтад тулгуурлан хөгжим судлалын онол бодролын үүднээс нягтлан судлаад "хуурын үлгэрт олон иж аяыг хэрэглэж байман сая нэг үлгэрийг бүрэн бүтэн хэлж чадна. Гэхдээ олон аянууд нь үндсэндээ өөрийн харьцангуй утга чанартай байдаг. Үүнээс болж хуурын үлгэрийн аяын үндсэн стиль бүрэлдсэн байна. Тэр нь даруй хуурын үлгэрийн тогтоол ая, эх ая ба хувиралт ая болно" (147 дугаар тал) хэмээн үзээд тогтоол ая, эх аяын онцлог, үүрэг зорилгыг анхлан тодруулж судлаад "Нэг нь үлгэрийн орчин ахуйг хөгжимлөг уур амьсгалаар бялхуулж үлгэрээ уянгалаг сонсголттой болгодог. Хоёр нь үлгэртээ ус сүү шиг ууссан нэгдээж үйл явдлаа чангатган товойлгодоогоороо амьд дүрслэг үлгэрийн орчин ахуйг бий болгодог. Гурав нь үлгэрийн өө сэвийг шавж хуурчид сэтгэн бодох цагийг олгон хуурчийн хоолойг амруулж үлгэрээ улам гоо төгөлдөр болгодог. Дөрөв нь хуурчийн дуулсан буюу гиншсэн аяс хөг нь үлгэрээ нэн илүү идлэг хүчтэй болгож чаддаг" (164 дугаар тал) гэсэн ерөнхий дүгнэлтэд хүрсэн байна. Эрдэмтэн Б. Цогт хуурын үлгэрийн уран сайхны онцлог мөн чанарыг судлахдаа бүрэн дүүрэн эх хэрэглэгдэхүүнд суурилж, туршлагатай хуурч, судлаачдын үзэл баримтлал ажиглалт дүгнэлтийг олон талаас нь харгалзан үзэж, өрнө дорны утга зохиол, урлагийн онолын үүднээс чадварлаг оновчтой задлан шинжилж, шинжлэх ухааны үндэслэлтэй сонирхотой хэлбэрээр нэгтгэн дүгнэж чадсан нь энэ судалгааны ажлын үнэ цэнэ, ач холбогдлыг тодорхой харуулж байна.

Хуурын үлгэр аман зохиолын нэгэн зүйлийн хувьд бусад төрөл зүйлүүдтэй харилцан холбоо хамааралтай хөгжиж иржээ. Тэр дундаа мангасын үлгэр болоод холбоотой хамгийн ойр харилцаатай байдаг онцлогтой. Хуурын үлгэр мангасын үлгэр, холбоотой ямар харьцаа хамааралд хөгжиж ирсэн онцлогийг судлаач "Хуурын үлгэр хийгээд мангасын үлгэр, холбоон харьцаа" гэсэн гуравдугаар бүлэгтээ судлан шинжилсэн байна. Хуурын үлгэр мангасын үлгэрийн холбоо хамаарлыг судлахдаа хуурч, мангасч хоёрын ижил ба ялгаатай тал, хуурын үлгэр ба мангасын үлгэрийн дүр дүрслэл, мотив, урлал хийцийн онцлог мөн чанарыг түүхэн хөгжлийн дунд нь нарийвчлан авч үзээд хуурын үлгэрийн эхэн үеийн хөгжилд мангасын үлгэрийн нөлөө ихээр туссан ч яваандаа хуурын үлгэр эрчимтэй хөгжиж олны хүртээл болсны нөлөөгөөр мангасын үлгэрийн орон зайг эзлэх болсон нь хуурын үлгэр мангасын үлгэрийг бодвол хүний аж амьдрал, нийгэм цаг үеийн онцлогийг илүү тусгасан дүр дүрслэл, хүний сэтгэлийн олон өнгө аясыг илэрхийлсэн хослол хөгжмийн ая эгшгийг ашиглаж байсантай холбоотойг тодруулжээ. Харин хуурын үлгэр ба холбоон харилцааг

Лаозар хуурчийн хэлсэн “Цэн Яо Цинь эмчилсэн нь” гэсэн хуурын үлгэрийн жишээн дээр тулгуурлан хуурын үлгэрийн хэсэг, хуурын холбоон хэсгийг тус тусад нь ялган явч үзжээ. Судлаачийн судласнаар бол өгүүлэн буй үлгэрийг хуурч 109 минут 50 секунд хэлсний “51 минут 49 секундын хуурын холбоо орсон байдаг. Энэ нь бүх үлгэрийн цагийн бараг зууны 47,18-ыг эзэлжээ. Үүнээс бид тус хуурын үлгэрт бараг хагас хэртээ цагаар нь хуурын холбоо ярьж байна гэдгийг мэдэж болно” (189 дүгээр тал) хэмээсэн дүгнэлтэд хүрсэн байна. Судлаач “хуурын холбоо бол хуурын үлгэр дэх хамгаас чухал нэг бүрэлдэхүүн хэсэг болохыг” (191 дүгээр тал) батлаад цааш нь хуурын холбоон онцлогуудыг нарийвчлан судлажээ. Хуурын үлгэр болоод бусад төрөл зүйлүүдийн холбоо хамаарлыг судлан шинжлэх замаар хуурын үлгэрийн өвөрмөц онцлог мөн чанарыг нарийвчлан тодруулсан нь онцлон тэмдэглүүштэй зүйл аж.

Хуурын үлгэр бол ард түмэнд үзэх жүжиг, сонсох хөгжим, унших ном, дуулах дууны үүргийг давхар гүйцэтгэж байсан тул хуурчаас асар их мэргэжил шаардагдах нь зайлшгүй. Тиймээс “хуурч нар бол олон зүйлийн авъяас чадвартай ардын урлагч болно.” (207 дугаар тал) Хуурч хэрхэн төрөн гардаг, ямар хэв намбаар хуурын үлгэрээ өгүүлдэг тухайг “Хуурч хийгээд хуурчийн урсгал” гэсэн дөрөвдүгээр бүлэгтээ авч үзсэн байна. Бүлгийн эхэнд хуурчийн ерөнхий онцлогийг өгүүлээд хуурч голдуу багш барих буюу багш таньж төрөгдөх, удам угсаа дагаж төрөгдөх, дур бахаасаа болж өөрсдөө сурч төрөгдөх гэсэн замаар хуурч болдогийг судлан тогтоожээ. Хуурч бүр өөрийн зан ааш, дуу хоолой, ертөнцийг үзэх үзэл, урлагийг ойлгох ойлголт зэргээрээ тус бүрдээ өөр өөр тул хуур хэлэх хэв намба нь тус бүрдээ онцлогтой байдаг. Үүнээс үүдээд хуурын үлгэрийн ерөнхий дэг урсгал үүсдэг байна. Судлаач уг асуудлыг тусгайлан судлаад нэг хэсэг хуурчид /Заана, Эрдэнэзүрх, Шарав, Бай Шүнь зэрэг/ “хүмүүст олгох хүмүүжил ба үлгэрийн утга учрыг чухалчлан үздэг тул үлгэр хэлэхдээ баялаг дүрслэг гүн ухаалаг хэллэгийг хэрэглэж үлгэрт гардаг үйл явдал ба хүмүүсийн хөдөлгөөнтэй уялдуулан амьдралын зүй ёсыг тодорхойлж хүмүүст өгөх” (218 дугаар тал) онцлог бүхий гүн ухаанлаг урсгал, нөгөө хэсэг нь /Ү Цянь Бао, Алт, Бао Сө Зу, Сүн Лин, Гунгаа зэрэг/ “хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж, уярал баяслын санаа сэтгэлгээг үүсгэх дээр хүч тавьдаг болохоор үлгэрийнхээ уянгаллын хэсгийг урт нам, эерүүн зөөлөн аялгуунд тааруулан урлагийн хүч чадлаа бадруулдаг” (219 дүгээр тал) онцлогтой яруу уянгат урсгал, мөн өөр нэг хэсэг нь /Жинь Бао Шань, Мөнгөнголт, Пао Бү Ляо, Үндэс зэрэг/ “сонсогчийн уран бахыг татах явдлыг чухалчилдаг тул үлгэр хэлэхдээ шог хэллэгийг тун анхаарч, заримдаа биеэрээ дүрслэн тоглож, үлгэрийг жүжиг шигээ болгодог” (219 дүгээр тал) онцлогтой шог хошин хэв намба бүхий урсгал байгааг тогтоожээ. Улмаар цааш нь нэг хэв намба бүхий урсгалын багш, шавь хоёр ч тус бүрдээ ихээхэн онцлогтой болохыг судлан тодруулсан байна. Судлаач өвөр монголын өргөн уудам нутагт үе залгамжлан хуур хэлэх хуурчдын өв сан, урланг судлаад тэдний ерөнхий ба тусгай онцлог хэв намбыг тодруулж, үүсгэсэн дэг сургуулиудыг нарийвчлан тогтоосон нь чухал ач холбогдолтой.

“Хуурын үлгэрийн зан үйл хийгээд нөлөө үйлдэл” гэсэн тавдугаар бүлэгтээ хуурын үлгэр зүүн орны монголчуудын зан үйлийн бүхэл бүтэн цогц ойлголт болсны учрыг судлан тайлбарласан байна. Хуурын үлгэрийг хуурч тусгай зорилгоор хуурдан хэлэхдээ тогтсон зан үйлийн дагуу эхэлж, өрнүүлж, жаргаадаг аж. Хуурын үлгэр хэлүүлэхээр хуурч залсан айл хотлын бэлтгэл, хуур хэлүүлэх болсон шалтгаан зэрэг нь зан үйлийн нарийн учир холбогдолтой байдаг байна. Хуурч тухайн хот айлын хуур хэлүүлэх болсон шалтгаантай уялдуулан тэдгээр хот айлын хүмүүстэй зөвлөлдөж байгаад

хуурын үлгэрээ сонгон ардын дуу хуур, аман яруу найраг зэргээр оршил хийж хэлээд үлгэрээ эхлүүлж, дунд нь жүжиг наадмын шинжтэй сонирхолтой хэлбэрээр өрнүүлээд эцэст нь үлгэрийнхээ үйл явдлыг хураангуйлан дүгнэх юм уу, ертөнцийн жам хууль хүний аж амьдралын сайн сайхантай уялдуулж хослуулсан магтаал ерөөлөөр, эсвэл байгаль дэлхийгээ магтан дуулсан хэлбэртэйгээр төгсгөдөг заншилтай байна. Хуурын үлгэрийг сонсож байгаа хүмүүс нь тусгай бэлтгэлтэйгээр үлгэрт шимтэн сууж, зорилготой байх тул үлгэр тэдний аж амьдралд, улмаар нийгэмд янз бүрээр нөлөөлдөг байна. Үүнийг судлаач энэ бүлэгтээ судлаад хуурын үлгэр хувь хүн болоод нийгэмд, ардын аман зохиолын бусад төрөл зүйлүүдэд ямагт эерэг сайнаар нөлөөлж ирсэн болохыг тодруулжээ. Тухайлбал, хуурын үлгэр нийгмийн хүмүүжил, төлөвшил, гоо сайхны мэдрэмж, аж амьдралын зүй зохист утга учрын ухаарал зэрэгт онцгой чухал нөлөөтэйг баримтад тулгуурлан өгүүлсэн байна. Иймд хуурын үлгэр бол хувь хүний аж амьдрал болоод нийгмийн ухамсар, харилцаа, мэдлэг боловсрол, төлөвшилд сайн сайхан талаас нь нөлөөлдөг өвөрмөц онцлогтой зүйл ажээ.

Эрдэмтэн Б. Цогт “Хуурын үлгэрийн судлал” хэмээх ганц сэдэвт бүтээлдээ монгол аман зохиолын нэгэн чухал хэсэг болох хуурын үлгэрийг иж бүрнээр нь судлан шинжилж, зохих үнэлэлт дүгнэлтэд хүрсэн байна. Тэр дундаа хуурын үлгэрийг судласан гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын судалгаа шинжилгээний бүтээлийг нэгтгэн авч үзээд өөрийн судалгаа шинжилгээний баталгаа нотолгоо болгон чадварлаг ашигласан нь түүнийг хэр зэрэг туршлагатай судлаач болохыг нотлоно. Эрдэмтэн Б. Цогт өвөр монгол төдийгүй монгол оронд хөгжин дэлгэрсэн хуурын үлгэрийг цуглуулж, судалгаа шинжилгээнийхээ эх хэрэглэгдэхүүн болгон ашигласан нь уг судалгаа баталгаа нотолгоотой, шинжлэх ухааны үндэслэл сайтай болсныг харуулна. Тийм учраас уг бүтээлийн монгол хэвлэлийн редактор профессор С. Байгалсайхан “Энэхүү ганц сэдэвт зохиол нь хятад монголын утга зохиолын харилцаанд ихээхэн үүрэгтэй бидний бэнсний үлгэр хэмээн нэрлэж занисан аман зохиолын төрлийг өвөр монгол нутагт хятадын бичгийн зохиол, монгол аман зохиолын уламжлалтай хослон дэлгэрсэн түүх, урлах эрдэм, зан үйлийн дэлгэрэнгүй мэдээлэл, судалгааны дүгнэлтүүдийг өгч байгаагаараа ач холбогдолтой юм” (3 дугаар тал) хэмээн онцлон өгүүлсэн байна.

Энэ бүтээлийг цогцод нь нэгтгэж үзвэл монгол ардын аман зохиол дахь хуурын үлгэрийн үүссэн нөхцөл байдал, учир шалтгаан, түүхэн хөгжил хувьсал, ач холбогдлыг нь гол гол хуурын үлгэрчдийн урын сан, урлан судлалтай нь иж бүрнээр нь судлан шинжилж тодорхой шийдэлд хүрсэн байна. Уг бүтээл хэвлэгдсэнээр хуурын үлгэр судлалд нэг шат ахиц гарчээ гэж үзэж байгаагаа өгүүлье.